

ТЭМДЭГЛЭЛ,
МЭДЭЭЛЭЛ

**ӨВӨР МОНГОЛД ЯВСАН
ТЭМДЭГЛЭЛ**

(Үргэлжлэл. Түрүүч нь 1987. No 2-т)

М. ЗЭНЭЭ

2. Сэтгэлд үлдсэн дурсамж

Хөх хотын Шинэ хот нэртэй шинээр байгуулсан зүүн захын 3 тоот хашаанд байх Өвөр Монголын харьяа Улаан мөчрийн орон сууцанд зочлон очсон өдрөөс монголчуудын уламжлалт зочломтгой аалинд сэтгэл сэргэж, хүндэтгэсэн, хүссэн, сонирхсон олон хүмүүстэй ажил амьдралынхаа тухай харилцан ярилцаж нэлээд хоногийг өнгөрөөж билээ.

Уулзсан хүмүүс манай улсын хөгжил, цэцэглэлт, хүмүүсийн амьдрал ахуй, монгол ёс заншил, соёл урлаг, шинжлэх ухаан, ардын боловсрол, эрүүл хамгааллын ажил үйлс, монгол хэл, уран зохиолын байдал гээд ер асууж сонирхохгүй зүйл алга байлаа. Баярласан, бахархсан сонирхсон, гайхсан олон хүний нүүр царай, сэтгэл бодолтой учирч тэдний асууж, сонирхсонд чадах ядахаар хариулж явахад олон зүйлийн эрэгцүүлэл толгойд бодогдож байсан.

Хүмүүсийн ярианаас үзэхэд «..нэг үеэ бодвол байдал өөрчлөгдөж, амьдрал дээрдэж байна. 1978 онд хуралдсан ХКН-ын Төв Хорооны III бүгд хурлаас хойш л ийм боллоо» гэсэн үгийг олонтой сонсож явлаа.

Айлд зочилж, хүмүүстэй учирч уулзаж явахад тэдний амьдрал хуучнаа бодвол эрхбиш дээрдсэн гэдэг нь илт байлаа. Айл гэрийн дотоод тавилга, өнгө зүс сайжирч хүн ардын өмсөж зүүх, идэж уух нь элбэгшсэн болохоор тэдний сэтгэл санаа өег өөдрөг харагдах болжээ. 1976 оноос өмнө хүн бүр улс төрийн бодлогоос айж эмээж, айл бүр ядуу зүдүү, идэх хоол хомс тарчиг, солиод өмсөх хувцас хүрэлцэхгүй, санаа сэтгэл гутрангуй, эдийн засагт тэгшитгэх систем үйлчилж байснаас хүмүүсийн ажиллах урам зориг хугарсан, амьдрах хүсэл тэмүүлэл мохоо болсон байсныг Хятадын хэвлэл сүүлийн жилүүдэд нэг биш удаа тэм дэглэж байсныг санаж байна.

Улс төрийн олон жилийн самуун будлиан-гачигдал зовлонгийн үндэс болж байсан 1960—1970 оны дунд үед «...хувцсыг шинээр нь 3 жил, хуучирхаар нь 3 жил, нөхөж сэлбээд 3 жил өмс...» гэдэг уриа явж, БНХАУ-ын иргэн болгон хөх хувцас, хар шаахай өмсөхийг шаардаж байсан бол өнөөдөр энэ байдлыг засч залруулах хандлага газар бүр хэрэгжиж байна. «Хятадын ард түмэн өнгө бүрийн цэцэг шиг алаглаж байх ёстой. Олон өнгөөр солонгорон туяарах цэцэгсийн дунд хүний нүд баясан, сэтгэл сэргэдгийн адил манай ард түмний хувцаслалтыг хараад гадаадын зочдын сэтгэл сэргэх ёстой гэсэн сурталчилгаа их явдаг болжээ. Сүүлийн жилүүдэд Хятадын залуучууд өнгө бүрийн хувцас их өмсөх болсон нь нүдэнд дулаан харагдах бөгөөд «хувцас бурхан, бие чөтгөр» гэдэг монгол ардын зүйр үгийг өөрийн эрхгүй санагдуулж билээ.

1 миллиард 70 сая гаруй хүн амтай Хятад шиг том оронд ажил олж хийнэ гэдэг амар асуудал биш ажээ. Бодит байдал ийм учраас ард түм-

ний амьдрах боломжийг дэмжих үүднээс «Хүн юу хийж чадна түүгээрээ ард түмэндээ болоод өөртөө үйлчил» гэсэн зарчим баримталж байна. Хүмүүс хувиараа жижиг засварын газар, элдэв гар үйлдвэр, олзворлох үйлдвэр хийгээд хувийн гуанз, дэлгүүр хүртэл нээн ажиллуулах аргаар амьдрал ахуйгаа дээш татаж байна. Хийсэн бүтээсэн зүйлээ зах зээл дээр чөлөөтэй зарж борлуулахыг зөвшөөрсөн болохоор ямарч үед зах зээл хувийн худалдаачдаар тасардаггүй байна. Хятадын Өмнөд мужуудаас жимс, ногоо, бараа таваар худалдахаар ирсэн хүмүүс олон байх бөгөөд зарим нь жижиг гар үйлдвэрлэл эрхлэж захиалга хувцас хийх, оёдлын болоод бусад газар байгуулах, хувиараа нүүрс бусад ашигт малтмал гарган борлуулах улмаар ӨМӨЗО-д суурьшин амьдрах явдал цөөнгүй болжээ. Улаанхад хот гэхэд л 10 гаруй нэр төрлийн хувийн уурхайд 10 мянга гаруй хүн ажиллаж байгаа ажээ. Их зуу аймгийн Ордосын тал нутаг, Хөлөнбуйр аймаг хийгээд бусад олон газар хүмүүс хувиараа нүүрс малтаж түүнийгээ борлуулан орлого олж байх бөгөөд Хөх хотоос Қинин орох засмал замын дагуу хувиараа алт олз Ворлож байгаа хүмүүс хэдэн зуугаараа ажиллаж байна. Тэд олсон алтаа улсад тушааж зохих үнийг нь авдаг ажээ. Хувийн дэлгүүр, гуанз, ресторан, цайны газар энд тэндгүй ажиллаж байна. Энд анхаарвал зохих нэг зүйл нь үнийн асуудал байх юм.

Улсаас гэрээгээр авч борлуулж байгаа бараан дээр хувь хүн өөрийн үзэмжээр үнэ нэмж худалддаг болохоор уг хүний амьдралын байдлаас шалтгаалж барааны үнэ янз бүр байдаг ажээ. Хөх хотын Их сургуулийн хашаанд байгаа олон тооны хувийн мухлагаар ороход нэг төрлийн барааны үнэ олон янз байсан бөгөөд хувиараа дэлгүүр эрхлэн байгаа хүмүүсийн зан ааш зөөлөн дулаан, үйлчилгээ хөнгөн шуурхай байгаа нь бараа хэдий сайн гүйвэл амьдралд нь төдий хэмжээгээр нөлөөлдөгтэй холбоотой мэт. Харин тэнд зэргэлдээ орших улсын дэлгүүрийн худалдагчид тогтмол цалинтай болохоор хүнд чин сэтгэлээр хөнгөн шуурхай үйлчлэхгүй, харьцаа хөндий, цаг нөхцөөсөн байдалтай байх нь тод ажиглагдана. Энэ байдлаас харахад хаана ч гэсэн, хүмүүсийн хувийн сонирхолыг нийгмийн сонирхолтой хослуулах явдал олон асуудлыг нааштай шийдэх гогцоо болдог юм байна гэсэн бодол төрүүлж билээ.

Олон арван жил улс төрийн элдэв кампанид нухлагдсан Хятад орон эдийн засгийн хувьд уналтад орж, улс төрийн бодлого нь ихэд дампуурч, ард түмний аж байдал туйлын хүнд болсон байсныг сүүлийн хэдэн жилд сүрхий өөд татаж эхэлж байгаа нь эдийн засгийн бодлогыг энэ мэт нэлээд өвөрмөц байдлаар хөтөлж эхэлсэнтэй холбоотой байна.

Хөдөө аж ахуйд байдал ямар болж байгааг харж ажиглаж явлаа. 1980 оноос Өвөр Монголд нэгдлүүдийг тарааж, мал бэлчээрийг хувь хүмүүст хариуцуулан өгч эхэлжээ. Үүнийг гэрээт хариуцлагын систем гэж хэвлэлд тэмдэглэж байгаа билээ. Мал, бэлчээр хоёрыг малчдад гэрээгээр хариуцуулан өгөхдөө газар газар өөр өөр байдлаар туршиж байна. Зарим газар өгч байгаа малдаа үнэ тогтоож, явцын дунд мөнгийг нь улсад тушаалган хувийн болгож байхад өөр газар малыг тодорхой хугацаанд хариулгах хооронд анх өгсөн малаас илүү өсгөснийг нь хувийн болгох арга хэрэглэж байгаа ажээ. Анх өгсөн малаас илүү өсгөсөн бүрийг хувийн болгох арга үр дүнд хүрч, хүмүүсийн мал маллах, өсгөх сонирхол улам нэмэгдэн амьдрал ахуй нь дээшлэх хандлагатай болжээ. Үүнээс үндэслэн малчид хувийн малаа өсгөхийн тулд

эх мал сувиаруулахгүй байх, улмаар зохиомол хээлтүүлэг хийж сураад үр дүнд хүрч байгаа тухай ч ярьж байна. Мал өсгөхийн тулд сүүлийн жилүүдэд авсан ийм ажил зарим талаар үр дүнд хүрч байгааг хэлэх хэрэгтэй. Яагаад гэвэл анх нэгдэл тараахад малчдад өгсөн мал хэдэн жил болсон ч хорогдохгүй, өөрөр хэлбэл хөдлөшгүй хөрөнгө болж үлддэг байна. Хэрэв улс шаардлагатай гэж үзээд малчнаас мал авах буюу малчид эргүүлж өгье гэж өөрсдөө хүсвэл анх тараасан малаа л авах ажээ. Анх авсан мал дээр нэмэгдсэн болгон тэр айлын хувийн мал болох учраас малчдын урам зориг дээшилж аль болох олон хувийн малтай болохыг эрмэлзэж байна.

Улс малаас гарах түүхий эдийн бэлтгэлийн үнийг шууд малчдад өгч эхэлсэн болохоор малчдын гар дээр мөнгө нэлээд хуримтлагдах болжээ. Мөнгөтэй болсон малчид гэрийн дотоод тавилга, унадаг дугуй, радис, магнитофон, оёдлын машин, зурагт радио, хөдөө аж ахуйн машин тэрчлэн зарим нь авто машин хүртэл худалдаж авсан жишээ байна. Хөдөлмөр, зүтгэлийн хүчээр мал нь олширч байгаа хүмүүс малаа хороохгүй, улам өсгөх гэсэн хандлагатай болж байгаа ажээ. Иймэрхүү байдлаар чинээлэгжиж байгаа өрх зуны цагт цагаан идээгээр гол хоол болгож мал нядлахгүй байхыг эрхэмлэдэг болсон нь нүүдлийн мал аж ахуй эрхлэж ирсэн монголчуудын эртний уламжлалт зан дадгаалд эргэн орж буйг харуулна. Бэлчээрийн мал аж ахуйг олон жил уналтын байдалд байлгасан өмнөх алдаагаа залруулах замар мал аж ахуйн хөдөлмөрийг малчдын хувийн сонирхолтой хослуулан урамшуулах өнөөгийн энэ аргыг хүмүүс муу зүйл биш гэж үзэж байна. Малчид хувийн малгүй болоод байсан өмнөх жилүүдэд нийгмийн мал элдэв шалтгаанаар ихэд хорогдож байсан ажээ. Учир нь нийгмийн малыг хороохгүй өсгөх гэж малчид хичнээн оролдсон ч тэднийг дэмжих дэмжлэг сул, амьдрал ахуй нь дээрдэхгүй болохоор ажиллах урам зориг эрс буурдаг байжээ.

Мал бэлчээрийг малчдад хариуцуулан өгч хувийн малтай болгох урамшуулал хэрэглэснээс хойш малчдын урам зориг ийнхүү дээшилж, мал өсөх хандлагатай болсон нь ажиглагдаж байна.

Газар тариаланд ч, мал аж ахуйд ч хэрэглэж байгаа өнөөгийн хариуцлагын системийн нэг ашигтай гэж үзэж байгаа тал нь хүн өөрийгөө хүнс тэжээлээр хангаад зогсохгүй, илүү бүтээгдэхүүнээрээ бусдыг хангах замаар материаллаг хэрэгцээгээ хангах аргад орж байгаа явдал гэж үзэж байна. Хүн амын байнга өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг улс дангаараа хангах боломжгүй учир хувийн болоод туслах аж ахуйг хөгжүүлэх замаар эл асуудлыг шийдэх нь үнэндээ ашигтай гэдгийг Өнөөгийн практик нотолж байна гэсэн яриа ч сонсогдож байлаа. Энэ бүхнээс дүгнэж үзэхэд Хятадын эдийн засгийг урагш нь ахиулахын тулд малчид, тариачид зэрэг олон хүн түүний дотор тэргүүний сэхээтнүүд ч идэвх санаачлага гаргаж байгаа ажээ.

Газрыг тариачдад түрээсээр эзэмшүүлж, түүнээс гарч буй бүтээгдэхүүнийг зах зээл дээр хувь хүмүүс чөлөөтэй борлуулах замаар бусдыг хүнсний ногоогоор хангах арга хэрэглэсэн нь үр дүнтэй болсон гэж хүмүүс ярьж байна. Тариа, ногоог ингэж борлуулах нь улс худалдагч томилж хий мөнгө үрэхгүй, унаа гаргаж бензин тос зарахгүй, жолооч, ачигч, буулгагч, нярав, нягтлан, дэлгүүрийн манаач, цэвэрлэгч гээд элдэв сул мөнгө урсахгүй харин хувь хүмүүсийн бараа борлуулсан мөнгөнөөс тодорхой хувиар татаж улс зөвхөн орлого олдгоороо их

ач холбогдолтой гэдэг тооцоог гаргажээ. Гэхдээ тариа, ногооны үнэ улирлын байдлаар тогтворгүй болж хэт нэмэгдэх хандлага гарахаас гадна бусад зөрчлүүд ч байдаг байна. Мал аж ахуй, газар тариаланд өнөөдөр хэрэглэж байгаа энэ мэт арга хөдөөнөөс хот руу нийгмийн малаа орхиод бөөн бөөнөөрөө амьдрахын эрхээр төв суурин газар барааддаг явдлыг багасгаж, хот суурин газрын механик өсөлтийг зогсооход ач холбогдол өгч байгаа тал байгаа ажээ.

Сүүлийн жилүүдэд ард түмний аж амьдрал хуучнаасаа зарим талаар дээшилж эхлэхээр зарим айлд хувийн мал хэт олшрох, хувьдаа хөдөө аж ахуйн болоод автомашин худалдан авах зэргээр нэг ёсондоо «баяжих» гэсэн хандлага их болж байгаа нь харагдана. Ийм хандлага нийт улс орны шинж чанартай болж эхэлбэл жижиг хөрөнгөтний аж ахуй эрхлэх арга барил, хандлага улам идэвхжих нь тодорхой хэрэг юм. 1987 оны 10 дугаар сарын сүүлчээр хуралдсан ХКН-ын XIII их хурлын материалд «хөдөлмөрийн орлогод... хэт зөрүү гаргахаас урьдчилан сэргийлэх боловч үнэн шударга хөдөлмөрийн үр дүнд бусдаас түрүүлэн чинээлэгжихэд тус дөхөм үзүүлнэ» гэсэн нь уг асуудлыг нэлээд анхааралтай авч үзэж байна уу? гэсэн сэтгэгдэл төрүүлж байна.

Аж ахуйн механизмыг хөтлөн жолоодох, социалист хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэхдээ нийт ард түмний эрх ашгийг хамгаалах, нийгмийг урагш ахиулах бодлогод захируулахгүй бол В. И. Лениний урьд Чилан анхааруулж байсан «...жижиг үйлдвэрлэл нь капитализм ба хөрөнгөтнийг үргэлж, өдөр тутам, цаг тутам, урсгалаараа, үл олноор нь төрүүлж байдаг»¹ гэсэн дүгнэлтэд хүргэж болзошгүй юм. Яагаад гэвэл өнөөдөр олон малтай болсон зарим айл өрх «хөлсөөр малчин» авч ажиллуулах, хувьдаа олон машинтай болсон зарим хүн тэр тоогоор жолооч хөлслөн авч машинуудаа таксийн журмаар ажиллуулах зэргээр хөрөнгө мөнгөтэй болох гэсэн хандлага газар авч баян хоосны ялгаа гарах, ангийн зөрчил үүсэх үндэс бий болж магадгүй байна гэж бодогдсон.

Өвөр Монголын төв Хөх хотод байхдаа урлаг соёлын олон зүтгэлт нүүдтэй тааралдаж, санал солилцож байсны нэг нь алдарт дуучин Буяндэлгэр гуай байлаа. Дуучин Буяндэлгэр 1955 онд Польш улсад болсон Дэлхийн залуучууд оюутны V их наадмаас Монгол ардын уртын дуу дуулж алтан медаль авч байсан хүн гэдгийг манай ард түмэн андахгүй. 1950-иад оны дундуур БНМАУ-д ирж монгол үзэгдчдийн чин Сэтгэлийн талархал хүртэж байснаа ч мартаагүй байгаа нь мэдээж. Харамсалтай нь энэ эмэгтэй хэвлэлд тэмдэглэснээр «Линь Бяо болоод дөрвийн бүлгийн хорлолоос» болж 20 шахам жил урлагаас хөндийрч, хүнд хэцүү хардалт хавчилтыг өнгөрөөжээ. Хятадын төв хэвлэл «Жэньминь жибао» сонинд бичсэнээр түүнийг 1978 онд цагаатгасныг би сайн санаж байна. Хөлөнбуйр аймгийн нутагт малчин ардын гэрт төрж өссөн, хөрслөг байрын зузаан бор царайтай, хөдөөнөө байсан бол нутаг усандаа гоо харагдах, хижээл насны сэргэлэн байрын энэ эмэгтэй хүнд хэцүү цаг мөчийг бие сэтгэлээрээ дааж өнгөрөөсөн гэмээргүй тэнхлүүн харагдаж билээ. Тэр одоо Хөх хот дахь Урлагийн дунд сургуулийн орлогч захирлаар ажиллаж байна. БНМАУ-д айлчлан тоглож явснаа, Монголын урлагийн мастеруудтай ижил дасал, ээжий ахай болж байснаа, дэлхийн залуучууд оюутны их наадмын алтан медаль авч хязгааргүй баярлаж байсан мартагдашгүй тэр баярт мөчөө дурсан ярихыг сонслоо. Хүнд хэцүү үеийг нь хөндөж, сэтгэл санаагийг нь гунигт оруулахыг

хүсээгүй болохоор элдвийн юм шалгаагүй боловч «...олон сар жилээр харанхуй нүхэнд суух шиг хүнд юм хаа байхав. Наранд гараад хар бол ажил хийх шиг жаргал хаа байхав. Хөдөлмөр хүнд хичнээн их хэрэгтэйг тэгэхэд л би ойлгосон шүү» гэж хэлсэн үг одоо ч чихэнд сонсогдож үргэлж нэгийг бодогдуулнам. Алдарт дуучин Буяндэлгэр гуай одоо хүртэл «алга болчихсон» алтан медалиа олж чадаагүй яваа ажээ.

Энэ мэт алдартай олон сэхээтэн хятадын улс төрийн бодлогын алдаа эндэгдэл, муу хийгээд сайн үйл явдлын амьд гэрч болон өнөөдөр чадллын хэрээр амьдарч, хөдөлмөрлөж явна. Залуу үеийн олон сэхээтнүүд улам ихийг хийхийн хүслэнд хөтлөгдөж, бүтээж туурвиж байгааг нүдээр үзэж явлаа. Тэдний хүсэл, мөрөөдөл, бодол сэтгэл, хэл яриа, удирдагчдын үндэстний бодлогод нэг үеэ бодвол «өөрчлөлт» орж «сайн тийшээ эргэж байна уу» гэсэн сэтгэгдэл төрөхөөр болж байгаад талархаж явсан. Гэвч цаашид яахыг үйл явдал харуулах болохоор өнгөцхөн танилцсан миний дүгнэлт ямар болохыг цаг хугацаа харуулах биз.

М. Лхасүрэнтэй 1985 оны 12-р сарын сүүлээр Улаанбаатар хотод нүүр учирч золгосноос хойш бид «ах дүүгийн сэтгэлээр» дотносож байнгын холбоотой байдаг болсныг өмнө цухас дурдсан билээ.

Бидний үерхэл улс төрийн бодлого, эдийн засгийн сонирхол, үндсэрхэг үзэлд хөтлөгдөж хоосон хуурамч, нялуун хөөргөн байдалд тогтоогүй, монгол үндэстний бие биеэ хүн ёсоор хүндэтгэх ойртох ижилсэх, ах дүүгийн ёсоор нөхөрлөж явах чин сэтгэлийн уламжлалт харьцаан дээр батжиж байгаа юм. Бидний үерхэл, нөхөрлөл тогтохоос өмнө М. Лхасүрэн түүний гэргий Төмөрцэцэг нарын амьдралыг улс төртэй холбон Хятадын хэвлэлд бичсэн шуугианыг би хэвлэлээрээ дамжуулан тайлбарлаж байсан болохоор бидний нөхөрлөл, ах дүүсэг харьцааг улс төртэй холбон ойлгох нь ч бас байсан.

М. Лхасүрэн БНМАУ-д айлчлан тоглолт хийгээд² буцсаныхаа дараа БНХАУ-ын хэвлэлд «Үзсэн далай, үзээгүй балай» нэртэй 4 цуврал хэвлүүлсэн юм. «Хун галуу», «Талын дуулал» зэрэг сэтгүүлд бичсэн уг цувралууддаа БНМАУ-д социализм байгуулах үйл явц хэрхэн өрнөж байгаа монголын хөдөлмөрчин ард түмэн хэрхэн ажиллаж амьдарч байгаа монгол үзэгчид Улаан мөчир чуулгын жүжигчдийг хэрхэ хүндэтгэн хүлээж авсан тухай, өөрийн нүдээр үзсэн зүйлийг дэлгэрэнгүй бичиж үнэн ба худлын зааг ялгааг багасган Өвөр Монгол уншигчдын халуун талархлыг хүлээсэн байна.

Түүний бичсэн нэг найруулаад «...бид ард түмнийхээ нөхөрлөлийг өвөрлөж очсон, мөн ч Монголын ард түмний нөхөрлөлийг өвөрлөж ирсэн. Сэтгэл тэнүүн, шижир алтан үе болоход амгалан хорвоод адилхан бүүвэйлэгдсэн ах дүү хөрштэйгээ уулзан золгох олдошгүй аз завшаан хүртсэн. Концерт эхлэхэд монгол, өвөрмонгол хоёр бүсгүй... гар гараасаа барилцан тайзнаа гарч төрөлх хэл төв халх аялгуу, сурсан хэл-хятадаар ээлжлэн зарлаж тоглолтыг нээхэд алга ташилтын дуу нижигнэн ах дүүсэг агаар-амьсгал дүүрэн бялхаж байлаа» гэсэн нь он удаан жил уулзаж чадаагүй монголчуудын сэтгэлийн үзүүрийг холбосон шижир уяа болсон болов уу гэлтэй. Ийм сурталчилгаа Хятад дахь монголчууд БНМАУ-ыг зөв ойлгоход үнэ цэнтэй зүйл болсон нь уулзсан хүн бүрийн байдлаас тодорхой ажиглагдаж байсныг хэлмээр байна.

Энэ тэмдэглэлийн өмнөх хэсэгт М. Лхасүрэнгийн гэргий БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд агсан Чжоу Энълайгийн өргөмөл охин (Чжоу Биньцзян) Төмөрцэцэгийн тухай «Өвөр монголчуудын дотор олсон нэр хүндтэй холбоотой байсан биз гэж бичээд энэ талаар дараа бичих цувралдаа тодорхой баримтаар хөндөх болно» гэж уншигчдад амласнаа санаж байна. Төмөрцэцэг 1952 онд Чжоу Энълайгийн төрсөн дүү Чжоу Энъшугийн гэрт төрсөн бөгөөд багаасаа ерөнхий сайдын гэрт өсчээ. Дунд сургууль төгссөн Төмөрцэцэг 16 насандаа 1968 онд Өвөр Монголд малчин болохоор шийдсэнийг Чжоу Энълай, түүний гэргий Дэн Инчао нар дэмжиж «үдэлтийн цай базаажээ. Өгсөн хоол нь гашуун өргөст хэмх, Гашуун бөгөөд сэрүүн чанартай энэ ногоог Чжоу Биньцзян амтархан иджээ. Юунд ийм хоолоор түүнийг үдсэнийг тэр хэрхэн ойлгох ажээ... гашуун зүдгүүрийг тэсвэрлэх хэрэгтэй гэсэн санаа юу, эсвэл Хятад улс гашуун зовлонд учраад байна. Ард түмний дунд очиж, ард түмэнтэй түүнийг хамт туулаарай гэсэн үг үү?» гэж «Өвөр Монголын залуучууд» сэтгүүлд бичжээ. Төмөрцэцэгийн төрсөн эцэг Чжоу Энъшу Хятадын Дотоод Явдлын Яаманд алба хааж байгаад «соёлын хувьсгал»-ын үед хардагдан баривчлагдаж, хүнд эрүү шүүлт, шорон гяндангийн улмаас тахир дутуу болж улмаар таалал төгссөн нь нөгөө л «Линь Бяо дөрвийн бүлгийн» хорлол ажээ. Би Бээжинд Төмөрцэцэгийн төрсөн эх Ван Шицзин гуайтай уулзаж ярилцаж билээ. Орос, англи хэлний багш байсан толиотой хижээл авгай өөрийн нөхрийн тухай оросоор сэтгэлд буутал дурсан ярьсны зэрэгцээ эхийгээ монгол удмын хүн байсан гэж хэлсэн нь их л анхаарал татаж билээ. Миний ээж монгол удмын хүн байсан болохоор миний охин Өвөр Монголд ажиллаж амьдрах, улмаар тэдний төлөө бие сэтгэлээ зориулахаар шийдсэн ч байж болох юм гэсэн тэр эмэгтэйн үгийг би их л хүндэтгэн сонссоноо тодхон санаж байна. Хятадын хэвлэлд М. Лхасүрэн, Чжоу, Төмөрцэцэг нарын тухай бичсэн. «Талд идээшсэн хайр» хэмээх найруулалд «... 16 настай жаал охин тал улайж, яс цайрч байсан 1968 онд энд (Өвөр Монголд-М. 3) ирсэн билээ» гээд анх Монгол нутагт ирсэн энэ охин мах идэж чадахгүй, гал түлж чадахгүй, морь унаж чадахгүй, монгол үг хэл мэдэхгүй байсан бол «... яваандаа малчдаас сурч, элэг нэгтэй» болж чадсан тухай өгүүлжээ». Хөдөө очоод жил болоогүй байтал нь «дахин сургаж, хүмүүжүүлэх ядуу ба ядуулаг малчин» гэсэн хачин жигтэй яриа тархжээ. Жирийн малчин ардууд «улсаас урвагч» болж, «Өвөр Монголын нууц ардын намын гишүүн» гэдэгт сэжиглэгдэн байцаагдаж, элдэв хилс хэрэгт шийтгэгдэн газар Тэнгэр нийлсэн гамшиг зовлон тохиолдож байсан болохоор ийнхүү Хятадын хэвлэлд «тал улайж, яс цайж байсан хэмээн онцлон тэмдэглэсэн нь тодорхой ажээ. Төмөрцэцэгийн итгэсэн, түшсэн монгол хүн болгон «дайсан болон хувирсан болохоор тэр яах ч учраа олохгүй болсон байна. Төвөөс (Хятадаас) хамт ирсэн «сэхээтэн» гэгч нар нь «ангийн тэмцлийн ширүүн будлианд» гавшгайлан оролцож, өдөр нь хэрэг төвөг үйлдээд шөнө нь үүдээ түгжиж унтахдаа дэрэн дороо сумтай буу, иштэй хутга, зарим нь сэлэм хүртэл хийж «сонор сэрэмжээ дээшлүүлж байсан тухай Төмөрцэцэг ярьсан нь ард түмний эсрэг яасан муухай жигшүүрт ажиллагаа зохион байгуулж байсан юм бэ гэдэг харамсах сэтгэл төрүүлж билээ. Энэ бүхнийг нүдээр үзсэн Төмөрцэцэг итгэж ядахдаа гэртээ захиа илгээсэн нь азаар «дөрвийн бүлгийн» хяналтанд өртсөнгүй, ерөнхий сайд агсан Чжоу Энълайгийн гарт хүрчээ.

Чжоу Эньлай өргөмөл охиныхоо захианаас Өвөр Монголд болж буй үйл явдлыг мэдээд уг асуудлыг шийдвэртэй буруушааж, зогсоосон гэж олон хүмүүс ярихыг сонслоо. Эл явдлаас хойш Өвөр Монголын ард түмэн Төмөрцэцэгийг хүнд хэцүү зовлонд амь үрэгдэх олон арван мянган монголчуудын амь насыг аварсан» ачтай охин гэж ихэд хүндэтгэн магтах болсон ажээ. Төмөрцэцэгийн монголчуудын дотор олсон анхны нэр хүндэнэ билээ. Монгол хүмүүс түүнтэй уулзаад энэ ач тусыг дурдан талархахад эгэл даруу, номхон зантай, намхан биетэй Төмөрцэцэг 6. «Үнэндээ би түүнийг өндөр ухамсараасаа хийсэн юм бишээ. Нүдээр үзэж, чихээр сонссон хийгээд амьдрал байдлаа гэр орондоо үнэнээр нь бичсэн төдий билээ. Тэмээ л жинхэнэ тэмээ болохоос биш, хоргол нь тэмээ болдоггүй шүү дээ» гэж даруухан хариулахыг би чихээрээ ч сонссон. Хэвлэлээс ч уншсан. 1968 онд ӨМӨЗО-ы Шилийн гол аймгийн Баруун үзэмчин хошууны малчин ард Пирэнвайн гуайнд эмэг эхийн удам даган монгол ёсоор 7 жил мал маллаж, морины давхианд бууж, мордож сурсан энэ охин анхны хайраа алдарт дуучин М. Лхасүрэнд тушааж, монгол айлын гал голомтонд бэр мөргөсөн нь Хятадын хэвлэлд тайлбарлаж байсан эртний монгол хаанд хятад бэр болж буусан Ван Чкаонзюн» -тэй адил эсэхийг тэр өөрөө хэлэх биз. Ямар ч байсан энэ асуудлыг хөндөж урьд өмнө хэвлэлд бичсэн надад гомдох учиргүй гэдгээ ил шулуухан хэлснийг л би чихээр сонссон. Яагаад гэвэл хайр дурлалыг нь улс төртэй холбон тайлбарлахыг надаас өмнө өөрийн нь Хэвлэл санаачилсан болохоор тэр байсан биз.

Төмөрцэцэг Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн Монгол утга зохиол судлах газрын орлогч захирлаар ажиллаж Гэсэрийн судалгаа хийхийн зэрэгцээ Хятад дахь монголчуудын дотор шижлэх ухааныг хөгжүүлэхийн ач холбогдол, монгол хэл бичгийг сэргээн хөгжүүлэх зэрэг асуудлаар өөрийн саналыг хэвлэлд нийтлүүлсэн нь олон Монголчуудын төдийгүй өнөөгийн Хятадын үндэстний талаархи төрийн бодлогод ч анхаарах ёстой санал болсон гэж хүмүүс үздэг бололтой. Түүний бичсэн «Ивэлсэн бодол», «Үг хэл-найрамдлын гүүр» зэрэг өгүүллийг анхаарч үзмээр санагддаг. Тэр «Ивэлсэн бодол» өгүүлэлдээ «...хотын монголчууд Шинжлэх ухааныг хүндэтгэдэг боловч эх хэлээ хүндэтгэхгүй сонин үзэгдэл зөндөө байна. Миний амьдарч байгаа байранд 24 айл байдаг. Тэдний дотор 4 хятад айлаас бусад нь Монгол юм. Өглөө бүр шуудан зөөгч маш олон сонин, сэтгүүл авчирч өгдөг. Хүмүүс захиалсан сонин, сэтгүүлээ авч дуусахад албанд (Улаан мөчир чуулгад. М. 3) ганц монгол сонин «царай муутай, гомдолтойхон үлддэг. Энэ явдал намайг удаан зовоож байгаа боловч олигтой хариулт олж чадахгүй явна. Нам төрөлх хэл бичгээ хөгжүүлэхийг шаардаж байхад... энэ монгол нөхөд чухам юу бодож явдагийн ухааныг олохгүй байна. Би хэдийгээр хятадаар хэлд орж, үг үсэг сурсан боловч хоёрдугаар эх хэл минь Монгол юм. Би энэ хэлний сүү шиг шимийг хүртэж, Монгол айлын гал голомтонд бэр мөрсөн болохоор монгол соёл мандан хөгжихөд хүч хөдөлмөрөө зориулна гэж мэрийж явдаг» хэмээн бичсэн нь монголчуудын дотор эх монгол хэлээ хөгжүүлэхэд чухал түлхэц болох сайхан санаа болсон байна гэж үзэлтэй. Ер нь сүүлийн жилүүдэд Хятад дахь Монголчуудын дотор Үндсэн хуулинд тэмдэглэсэн «цөөнх үндэстнүүд» эх хэлээ сурах, хөгжүүлэх хөдөлгөөн ихээхэн өрнөж байгааг дахин тэмдэглэмээр байна. «Хятад хэл сурснаа их эрдэм чадвартайд тооцогчид бол бурам долоосон хүүхэд эхийнхээ сүүг

гашуун гээд нулимав» гэдэгтэй адил хэмээн хэвлэлд нэг биш удаа шүүмжилж байгаа нь үүнийг бүр ч тодорхой гэрчлэх ажээ. Монгол хэл бичгийг хөгжүүлэх ажилд «Хятадын засгийн газрын дэмжлэгтэй» нийт монголчууд идэвхтэй оролцож байгаа нь хятад биш үндэстний талаар явуулах бодлогод зарим өөрчлөлт орж байгаа хийгээд «цөөнх» үндэстний соёлын асуудлаар санал, санаачлага их гарч байгаатай холбоотой юм.

Төмөрцэцэг «Үг хэл-найрамдлын гүүр» гэдэг өгүүлэлдээ монголчууд хятад хэл заавал сурах ёстой гэж үздэгийг «буруушаагаад», Хятад хүмүүс монгол хэл сурах нь найрамдлыг «бэхжүүлэхэд» ихээхэн ач холбогдолтой гэж тэмдэглэжээ. Энэ өгүүлэлд «...манай өөртөө засах орны хятад нөхөд монгол хэл сурах бүрэн бололцоо бий. Хавьтаж ойртоогүй гадаад хэлийг халширалгүй сурч, хэлж ярьж байтлаа хамт амьдарч байгаа Монгол үндэстний хэлийг хаяандаа хаядаг нь юуны учир билээ. Зарим нь (хятадууд —М. 3) бүр монголчууд хоорондоо эх хэлээрээ ярилцахыг төвөгшөөх байдал ч үзүүлдэг. Энэ бол хятад биш үндэстнийг хүндэтгэхгүй байгаагийн сонин жигтэй үзэгдэл гэж би үзнэ. Хэрэв Монголчууд хятад хэл сурахгүй бол хятадууд юу гэж үзэх вэ? Үүнтэй адил Монгол хэл сурахгүй хятадуудын талаар Монголчууд юм бодох нь буруу гэж үү? ...Монгол нөхөд намайг хятад хүн гэдгийг мартаад чинсэтгэлийн үгээ хүртэл ярьдаг нь үг хэл найрамдал нөхөрлөлийн гүүр гэдгийг харуулж байгаа баримт мөн... Хятад биш үндэстэн хятад үндэстэнд хэрхэн хандаж байгаагаар нь тэдний ухамсрын өндөр намыг хэмжиж болохгүй. Тэд бидэнтэй адил үндэстнээ хайрлаж, үндэстнээ хүндэтгэдгийг бид буруу гэж үзэх ёсгүй. Ингэж үндэстнээ хайрлахыг бүрэн зөвшөөрөх хэрэгтэй гэж тэмдэглэсэн нь санамсаргүй хэрэг биш биз ээ.

Энэ мэтээр хятад дахь Монгол үндэстний урлаг, утга зохиол бусад зүйлийг хөгжүүлэх, улс төрийн талаар хэт ачаалалтай «хянахыг» багасгах, эдийн засгийн хувьд хөл дээр нь зогсоох, сэхээтнүүдийн чөлөөт «сэтгэлгээг» дэмжих, хувийн аж ахуйг хөгжүүлэх замаар ард түмний материаллаг хангамжийг дээшлүүлэх зэрэг нилээд арга хэмжээ зохион байгуулж байгаа нь ажиглагдаж байлаа.

Хоёр улсын харьцаа зөөлрөх тийш эргэх боломжтой энэ үед ах дүү ёсоор үерхсэн хоёр найзынхаа хүссэнээр ӨМӨЗО хийгээд Бээжин, Хөх хот зэрэг нэлээд газраар тойрон үзэж, Хятадын ард түмний амьдрал, байдалтай танилцсандаа талархаж яваагаа эцэст нь тэмдэглэлтэй. Нам засгийн хайр халамж, ард түмнийхээ итгэл найдварыг биелүүлэх чин хүсэлд хөтлөгдөн явдаг бидний нөхөд цаашид ч харилцаа холбоогоо улам зузаатган нөхөрлөж явах талд зогсох болно. Улс орны харилцаа сайжирч, ард түмний нөхөрлөл гүнзгийрч, үр ач нар минь үг хэлээ ололцож, үеийн үед бие биенээ үнэнч сэтгэлээр хүндэтгэж явах сайн цагийн үүдийг энэ аялал минь нээсэн байгаасай гэж үргэлж бодно. Манай ард түмнүүдийн уламжлалт харилцаа машид хөгжиж өрнөн дэлгэрэхийн өлзийтэй ерөөл бат орших болтугай.

Хөх хот—Бээжин—Улаанбаатар